



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат
компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин болон контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Д.Баатартай байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Д.Баатартай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001667